

ЖЕНДЭРИЙН ҮНДЭСНИЙ ХОРООНЫ АЖЛЫН АЛБАНЫ 2019 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2019.07.04

НЭГ. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮНГИЙН ТАНИЛЦУУЛГА

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай Монгол Улсын хууль болон Засгийн газрын 323 дугаар тогтоолоор батлагдсан Жендэрийн үндэсний хорооны дүрэмд заасан Жендэрийн үндэсний хороо, түүний Ажлын албаны бүрэн эрх, чиг үүргийн хэмжээнд 2019 онд дэвшүүлсэн зорилт, батлагдсан хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэх үндсэн үйл ажиллагааны зэрэгцээ Засгийн газрын Хэрэг Эрхлэх Газраас өгсөн зөвлөмж чиглэлийг удирдлага болгон Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангахад анхаарч ажиллалаа.

Жендэрийн үндэсний хорооны Ажлын албаны 2019 оны үйл ажиллагааны үр дүнг дараах 6 чиглэлээр хураангуйлан танилцуулж байна. Үүнд:

- Жендэрийн тэгш байдлыг хангах бодлого, хөтөлбөр, тусгай арга хэмжээг боловсруулах, хэрэгжүүлэх, түүний биелэлтэд хяналт тавих ажлыг зохион байгуулах;
- Жендэрийн тэгш байдлыг хангах бодлогыг хэрэгжүүлэх эдийн засаг, эрх зүйн баталгааг бүрдүүлэх, түүнийг боловсруулах ажлыг арга зүйн удирдлагаар хангах;
- Жендэрийн тэгш байдлыг хангахад шаардлагатай үндэсний чадавхыг төрийн байгууллагын болон нийгмийн хүрээнд бэхжүүлэх;
- Жендэрийн тэгш байдлыг хангах бодлого, үйл ажиллагааг хэвлэл мэдээлэл, олон нийтийн болон хувийн хэвшлийн байгууллагатай хамтран зохион байгуулах;
- Жендэрийн тэгш байдлын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн төлөв байдлын талаар судалгаа, дүн шинжилгээний ажлыг зохион байгуулах;
- Жендэрийн тэгш байдлыг хангах асуудлаар олон улсын байгууллага, гадаад улстай хийх хамтын ажиллагааг өргөжүүлэх.

1.1. Жендэрийн тэгш байдлыг хангах бодлого, хөтөлбөр, тусгай арга хэмжээг боловсруулах, хэрэгжүүлэх, түүний биелэлтэд хяналт тавих ажлыг зохион байгуулах чиглэлээр

• Жендэрийн салбар зөвлөл, яам, агентлаг, харъяа байууллагын түвшинд баримтлах жендэрийн бодлого боловсруулах, батлуулах ажилд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэн хамтран ажиллав. 2017-2018 онд 4 салбарын бодлого, нийт 7 салбарын бодлого батлагдаад байна. 2019 онд 3 салбар жендэрийн бодлогоо батлуулахаар ажиллаж байна. Тухайлбал:

- Батлан хамгаалах салбарт хэрэгжих жендэрийн нэгдсэн бодлого, үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах ажлын хүрээнд салбарын албан хаагчдад сургалт нөлөөллийн ажил зохион байгуулав.
- Эрүүл мэндийн салбарт оролцоонд суурилсан жендэрийн үнэлгээ хийх, тус үнэлгээнд суурилсан жендэрийн нэгдсэн бодлого, үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах ажлын даалгавар, зөвлөх үйлчилгээний гэрээг боловсруулж, зөвлөхийн ажлын хөлсийг шийдвэрлэж ажиллав. Тус ажлын хүрээнд ЭМЯ-ны

- нийт албан хаагчдад зориулсан “Салбарын жендэрийн бодлого, ач холбогдол” сэдвээр сургалт, семинар зохион байгууллаа.
- Дипломат байгууллагуудад хэрэгжих жендэрийн нэгдсэн бодлого боловсруулах хүрээнд оролцоонд суурилсан жендэрийн үнэлгээ хийж, тус яамны нийт албан хаагчдад зориулсан “Жендэрийн тэгш байдал ба бодлого төлөвлөлт” сэдвээр сургалт, семинар зохион байгуулж, яамны 70 орчим албан хаагчийг хамрууллаа.
 - Жендэрийн салбар хороо, аймаг, нийслэл, дүүргийн түвшинд баримтлах жендэрийн дэд хөтөлбөр боловсруулах, батлуулах ажлын хүрээнд өнгөрсөн хугацаанд 14 аймгийн дэд хөтөлбөрийг батлуулсан. 2019 онд 2 аймгийн дэд хөтөлбөр батлагдаж, 2 аймаг дэд хөтөлбөрийн төслийг боловсруулж батлуулахад бэлэн болсон, 3 аймаг дэд хөтөлбөр боловсруулах ажлыг эхлүүлээд байна. Тухайлбал:
 - Хөвсгөл, Өвөрхангай аймгууд жендэрийн дэд хөтөлбөрөө батлуулсан бөгөөд Сүхбаатар, Дундговь аймаг дэд хөтөлбөрөө боловсруулаад ИТХ батлуулахаар, Архангай, Хэнтий, Орхон аймгууд жендэрийн нөхцөл байдлын дүн шинжилгээний ажлыг эхлүүлээд байна. Архангай, Хэнтий аймагт дэмжлэг үзүүлж ажиллалаа.
 - Нийслэл, нийслэлийн 9 дүүрэгт тухайн шатны Засаг даргын захирамжаар жендэрийн дэд хөтөлбөр боловсруулах 10 ажлын хэсэг байгуулагдав. Тус ажлын хүрээнд жендэрийн нөхцөл байдлын судалгаа, дүн шинжилгээ хийгдэж байгаа бөгөөд үр дүн, онцлог хэрэгцээнд суурилсан дэд хөтөлбөрийн төсөл боловсруулах ажил хийгдэж байна.
 - Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт, орон нутгийн дэд хөтөлбөр боловсруулах ажлын үйл явц, үр дүнтэй газар дээр нь танилцах, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх уулзалтыг нийслэлийн 9 дүүрэгт зохион байгуулж, жендэрийн салбар хорооны гишүүдтэй уулзаж санал, мэдээлэл солилцов. Уулзалтын мөрөөр Үндэсний хөтөлбөр болон дүүргийн жендэрийн дэд хөтөлбөрийн хэрэгжилтэд тодорхой дэмжлэгийг үзүүлэхээр болов.
 - “Ажлын байрыг жендэрийн мэдрэмжтэй болгох талаар үндэсний хэмжээнд баримтлах бодлого”-ын төслийн хэлэлцүүлгийг МҮЭХолбоотой хамтран зохион байгууллаа. Семинарт МҮЭХ, АОЭНХ, ҮЭХ-ын төлөөлөл нийт 40 орчим хүн оролцлоо.
 - Тогтвортой хөгжлийн зорилтын шалгуур үзүүлэлтийг үнэлэх, дахин боловсруулах ажлын хүрээнд 8 дэд ажлын хэсэгт ажиллаж, нийт 9 удаагийн ажлын хэсгийн хуралд оролцож, холбогдох саналуудыг боловсруулж, хүргүүлэн ажиллалаа.
 - Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3.12-т заасны дагуу Монгол Улсад жендэрийн эрх тэгш байдлыг хангахад олон жил, тасралтгүй, үр бүтээлтэй ажиллаж, үнэтэй хувь нэмэр оруулсан нэр бүхий хүмүүсийг Хорооноос Төрийн дээд шагналд нэр дэвшүүлсэн. Улмаар Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2019 оны 42 дугаар зарлигаар “Алтан гадас” одонгоор шагнагдсан Жендэрийн үндэсний шинжээч, “Хөгжлийн замнал сан” ТББ-ын гүйцэтгэх захирал Т.Амгалан, Нэгдсэн Үндэстний байгууллагын Хүн амын сангийн Жендэрийн хөтөлбөрийн зохицуулагч Б.Оюун нарт Монгол Улсын Ерөнхий сайд, Жендэрийн үндэсний хорооны дарга У.Хүрэлсүх шагналыг гардуулж хүндэтгэл үзүүллээ.
 - 2018 онд Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд манлайлан ажилласан Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Жендэрийн салбар зөвлөл, Баянхонгор, Дорнод аймгийн Жендэрийн салбар хороог тус тус өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнаж урамшууллаа.

1.2. Жендэрийн тэгш байдлыг хангах бодлогыг хэрэгжүүлэх эдийн засаг, эрх зүйн баталгааг бүрдүүлэх, түүнийг боловсруулах ажлыг арга зүйн удирдлагаар хангах чиглэлээр

- Засгийн газрын 2018 оны 111 дүгээр тогтоолоор Жендэрийн үндэсний хорооны Ажлын албыг 2019 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн Монгол Улсын Ерөнхий сайдын дэргэд ажиллуулахаар шийдвэрлэж, Засгийн газрын 285 дугаар тогтоолоор Ажлын албаны орон тоог 8 болгон нэмэгдүүлсэн. Жендэрийн үндэсний хорооны Ажлын алба нь 8 орон тоотойгоор ажиллах болсонтой холбогдуулан 2019 оны улсын төсөвт цалингийн сан болон үйл ажиллагааны зардлыг Ерөнхий сайдын төсвийн багцад тусган, 706.8 сая төгрөгийг баталсан.

- Ажлын алба нь ХНХЯ-ны бүтцээс салж бие даан үйл ажиллагаа явуулах болсонтой холбоотойгоор Төрийн өмчийн байр түрээслэх асуудлыг Хорооны даргад танилцуулж улмаар Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар руу чиглэл өгсөн. Энэ хүрээнд Ерөнхий сайдын Ажлын алба, Гадаад харилцааны яам, Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газрууд хамтран ажилласны үр дүнд Хорооны Ажлын алба нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар” ТӨҮГ, Жендэрийн үндэсний хороо нарын гурван талаас байгуулсан 2019 оны ТӨ-2019/003 тоот “Төрийн өөрийн өмчийн түрээсийн гэрээ”-ний дагуу Сүхбаатар дүүргийн 6 дугаар хороонд байрлах /хуучнаар Бүгд Найрамдах Куба Улсын Элчин сайдын яам байрлаж байсан/ 2 давхар оффисын байранд байрлан үйл ажиллагаагаа явуулж байна.

- Жендэрийн үндэсний хорооны 2019 оны ээлжит хуралдааныг зохион байгуулсан. Хуралдаанаар Жендэрийн үндэсний хорооны 2018 оны үйл ажиллагааны тайланг танилцуулж, 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хэлэлцэж Жендэрийн үндэсний хорооны даргын тогтоолоор батлан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

- Жендэрийн үндэсний хорооны Ажлын албаны хөдөлмөрийн дотоод журам болон 2019 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж Жендэрийн үндэсний хорооны Ажлын албаны даргын тушаалаар батлан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

- Засгийн газрын 2018 оны 22 дугаар тогтоолоор батлагдсан “Чиг үүрэг дахин хуваарилах аргачлал”-ыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Ерөнхий сайдын харъяа байгууллагуудын чиг үүргийн шинжилгээ хийх, дахин хуваарилах санал боловсруулах ажлын хүрээнд Ажлын хэсэг байгуулж ажиллав. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай Монгол Улсын хуульд заасан Жендэрийн үндэсний хорооны чиг үүргийн хүрээнд “Чиг үүргийн шинжилгээ, дахин хуваарилалт”-ын www.function.gov.mn цахим системд 16 дэд чиг үүрэгт хамаарах Монгол Улсын хуулийн 27 заалтыг оруулж шинжилгээг хийж, чиг үүрэг дахин хуваарилах саналыг бэлтгэн ЗГХЭГ-т хүргүүлэв.

1.3. Жендэрийн тэгш байдлыг хангахад шаардлагатай үндэсний чадавхыг төрийн байгууллагын болон нийгмийн хүрээнд бэхжүүлэх ажлыг зохион байгуулах чиглэлээр

- Монгол Улсын Засгийн газар болон НҮБ-ын Хүн амын сангийн хамтын санхүүжилтээр Жендэрийн үндэсний хорооны дэргэд Сургалт, судалгааны танхим байгууллаа.

- “Жендэр ба бодлого төлөвлөлт” сургагч багшийн гарын авлага, модуль боловсруулж, хэвлүүлэв. Тус гарын авлага, модулийн хүрээнд сургалт зохион байгуулж, төрийн захиргааны төв болон харъяа агентлагуудын жендэрийн асуудал хариуцсан 31 төрийн албан хаагчийг сургагчаар багшаар бэлтгэв.

- Удирдах ажилтанд зориулсан жендэрийн цахим сургалтын модулийг Жендэрийн үндэсний хорооны цахим сайт болон Хүний Эхрийн Үндэсний Комиссын цахим сургалтын кампуст байршуулсан. Тус цахим сургалтад 527 удирдах ажилтан хамрагдсанаас 302 удирдах ажилтан шалгалтад тэнцсэн байна. Үүнээс 268 цагдаагийн удирдах албан хаагч сургалтад хамрагдсанаас тэнцсэн 189, дүүргийн удирдах ажилтнуудад зориулсан нэгдсэн сургалтын хүрээнд нийт 259 удирдах ажилтан цахим сургалтад хамрагдсанаас тэнцсэн 113 албан хаагчид гэрчилгээг олгов.

- Орон нутгийн жендэрийн салбар хороодын гишүүдийг чадавхжуулах, жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр, орон нутгийн жендэрийн дэд хөтөлбөрийг дэмжих зорилгоор 21 аймгийн сайн туршлагыг танилцуулах, харилцан суралцах Бүсчилсэн семинар"-ыг Завхан, Дархан-Уул аймагт тус тус зохион байгуулсан. Семинарт нийт 95 төрийн албан хаагч хамрагдсанаас 38 удирдах албан тушаалтан, 57 жендэрийн асуудал хариуцсан болон бусад холбогдох мэргэжилтнүүд оролцлоо. Семинараар Архангай аймгийн "Ажил, ар-гэрийн тэнцвэрт байдлыг анхаарсан жендэрийн мэдрэмжтэй байгууллагын соёлыг төлөвшүүлсэн байгууллагын үйл ажиллагаа", Баянхонгор аймгийн "Жендэрт суурилсан хүчирхийллийг таслан зогсоох, гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийг хамгаалах төр, ИНБ-ын хамтын ажиллагаа", Увс аймгийн "Залуу малчин өрхийн хүүхдийн боловсрол", Орхон аймгийн Эрэгтэйчүүдийн кабинет байгуулах, түүний үйл ажиллагааг тогтвортой дэмжих, Төв аймгийн "Байгаль орчноо хамгаалах үйл ажиллагаанд жендэрийн асуудлыг нэвтрүүлэх, Өмнөговь аймгийн "Уул уурхайн компанитай түншилж, орон нутагтаа жендэрийн хувьд үр нөлөө үзүүлэхүйц үйл ажиллагааг хамтран хэрэгжүүлэх, Сэлэнгэ аймгийн "Жендэрийн статистикийн бютень хэвлэн түгээх" зэрэг ажлуудыг үндэсний хэмжээнд сайн туршлага болгож түгээн дэлгэрүүлэхээр болов.

- Нийслэл, нийслэлийн 9 дүүргийн ЗДТГ болон харъяа агентлагуудын удирдах албан тушаалтнуудад зориулсан "Жендэрийн тэгш байдлын үзэл баримтлалыг бодлого, төлөвлөлт, үйл ажиллагаанд тусгах нь" сургалтыг зохион байгууллаа. Тус сургалтад нийт 212 удирдах албан тушаалтан хамрагдсан бөгөөд үүнээс эрэгтэй 98, эмэгтэй 114 албан хаагч оролцлоо.

- Төрийн албан хаагчийн мэргэшүүлэх багц сургалтын агуулгад жендэрийн агуулгыг нэвтрүүлэх ажлыг Удирдлагын академитай хамтран хэрэгжүүлэх ажлыг эхлүүллээ. Энэ хүрээнд Ажлын албанаас боловсруулсан төрийн албан хаагчдад зориулсан "Жендэр ба бодлого төлөвлөлт" сургагч багшийн гарын авлага, Төрийн удирдах албан тушаалтнуудад зориулсан цахим сургалтын модулиудыг багц сургалтын агуулгад тусгуулахаар хүргүүлээд байна.

- "Монгол Улсын тогтвортой хөгжлийн зорилтын хяналтад жендэрийн статистикийг гаргах, ашиглах нь" сэдэвт 3 өдрийн сургалтыг Жендэрийн үндэсний хороо, Үндэсний статистикийн хороо, НҮБ-ын эмэгтэйчүүдийн байгууллагатай хамтран зохион байгуулсан. Тус сургалтад мэдээлэл гаргагч, мэдээллийн хэрэглэгчид, жендэрийн статистик мэдээллийн хэрэглэгч, мэдээллийг боловсруулан гаргагч (төр, төрийн бус байгууллага, сэтгүүлчдийн төлөөлөл) талуудыг оролцууллаа.

- Төр, төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, аж ахуйн нэгж байгууллагын санаачилгаар үндэсний, салбарын, байгууллагын түвшинд зохион байгуулагдаж буй 20 гаруй арга хэмжээнд тухайн байгууллагын хүсэлтийн дагуу өөрсдийн хамаарах чиглэлээр илтгэл, мэдээлэл, сургалт хийж оролцлоо.

1.4. Жендэрийн тэгш байдлыг хангах төрийн бодлого, үйл ажиллагааг хэвлэл мэдээлэл, олон нийтийн болон хувийн хэвшлийн байгууллагатай хамтран зохион байгуулах чиглэлээр

- ОУ-ын Эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийн хүрээнд жендэр, жендэрт суурилсан хүчирхийлэл, түүнийг таслан зогсоох чиглэлээр оюутан залуучуудын ойлголт мэдлэгийг нэмэгдүүлэх, таниулан сурталчилах кампанит ажил зохион байгуулсан бөгөөд дараах ажлуудыг гүйцэтгэв. Үүнд:
 - Оюутан залуучуудад зориулсан семинар: МУИС, ШУТИС, ХИС, ХААИС, МУБИС-ийн нийт 252 оюутанд (үүнээс 199 эмэгтэй) 2019 оны 2 дугаар сарын 14-20-ны өдрүүдэд семинар зохион байгуулж, жендэр/ЖСХ-ийн талаарх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлсэн.
 - “Гэр бүлийн үнэт зүйл-итгэлцэл: хүчирхийллийг бууруулахад залуучуудын оролцоо” эрдэм шинжилгээний хурал: 2 үе шаттай зохион байгуулсан. Тус эрдэм шинжилгээний хуралд нийт 10 их дээд сургууль (ХСИС-21, МУИС-16, МУБИС-14, ХИС-8, ИЗИС-5, Отгонтэнгэр-2, СЭЗИС-4, АШУУИС-2, Шихихутуг Их сургууль-3)-ийн 112 (үүнээс 49 эрэгтэй) оюутны 75 илтгэл оролцсон. Үүнээс 10 (нийт 17 оюутан, үүнээс 8 эрэгтэй) илтгэлийг 1 дүгээр шатанд, 5 илтгэлийг 2 дугаар шатанд шалгаруулан хэлэлцүүлж, байр эзлүүлэв.
 - ЭШХурлын үйл ажиллагааг TV9, парламент телевиз, Ийгл ТВ, TV8 телевиз, Зиндаа.mn сайтууд сурвалжилж ЖСХ/ГБХ-ээс урьдчилан сэргийлэх чиглэлийн мэдээ, мэдээллийг олон нийтэд түгээв.
 - *Үзэсгэлэн*: ЭШХ-ын эхний шатанд шалгарсан 10 оюутны бүтээлийг эмхэтгэл болгон хэвлэж, бүтээлүүдээр үзэсгэлэн гаргаж оролцогчид болон телевизээр сурталчилав.
 - *Видео, хэвлэл мэдээллийн ажил*:
 - Жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр богино хэмжээний видео хийж, 2019 оны 3 дугаар сарын 7, 8-ны өдрүүдэд SBN, ETV, VTV телевизүүдээр өдрийн 3 удаагийн давталттайгаар цацагдсан.
 - МҮОНТ телевизтэй хамтран “Жендэр хөгжлийн стратеги мөн үү?” сэдвээр холбогдох төр, төрийн бус байгууллагууд (нийт 45 оролцогчидтой)-ын төлөөллийг оролцуулсан шууд хэлэлцүүлэг хийж 3 сарын 7, 8-ны өдрүүдэд тус бүр 1 удаагийн давталттайгаар цацагдсан.
 - Олон улсын Эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан 2019 оны 2 дугаар сарын 25-аас 3 дугаар сарын 8-ны өдрүүдэд News.mn, UBS ТВ, Ийгл ТВ-ийн Сошиал контент, Өлзий ТВ-ийн өглөө хөтөлбөр, МҮОНТ өглөө хөтөлбөр, ТВ9 телевизийн зочин нэвтрүүлэгт оролцон Жендэр, жендэрт суурилсан хүчирхийллийн асуудлаар мэдээ, мэдээлэл бэлтгэн цацав. Нэвтрүүлгүүдэд МУ-ын Ерөнхий сайдын жендэрийн зөвлөх Д.Сүхжаргалмаа, Жендэрийн үндэсний хорооны нарийн бичгийн дарга бөгөөд ажлын албаны дарга Т.Энхбаяр, ажлын албаны бодлого төлөвлөлт, төсөвлөлт хариуцсан ахлах мэргэжилтэн С.Батцэцэг нар оролцож мэдээлэл хийсэн.
- Жендэрийн үндэсний хороо, Монголын Үндэсний Олон Нийтийн Радио Телевиз хамтран ажиллах Харилцан ойлголцлын санамж бичиг байгууллаа. Энэхүү санамж бичгийн зорилго нь жендэрийн талаар төрөөс баримталж буй бодлогыг таниулах, сурталчлах, бүх нийтийн жендэрийн мэдлэгийг дээшлүүлэх чиглэлээр тусгайлсан нэвтрүүлэг, мэдээлэл бэлтгэн хүргэх, соён гэгээрлийн ажлыг тасралтгүй өрнүүлэхэд оршино. МҮОНРТ-тэй байгуулсан хамтын ажиллагааны хүрээнд дараах нэвтрүүлгүүдийг бэлтгэн цацав.

- МҮОНТ-ийн Нээлттэй хором нэвтрүүлгээр “Монгол Улсын Жендэрийн өнөөгийн нөхцөл байдал гарц шийдэл” сэдвээр холбогдох талуудыг оролцуулсан хэлэлцүүлэг,
- МҮОНТ-ийн Цаг үе үзэл бодол нэвтрүүлгээр “Жендэрийн талаарх ойлголт, жендэр гэж юу вэ” сэдвээр ЖҮХАА-ны дарга Т.Энхбаярын оролцсон ярилцлага,
- Завхан, Дархан-Уул аймагт зохион байгуулсан бүсийн сургалтууд болон “Монгол улсын жендэрийн нөхцөл байдлын дүн шинжилгээ: 2005 оноос өнөөг хүртэлх ололт ба сургамж” дүн шинжилгээний тайланг танилцуулах арга хэмжээний мэдээллийг МҮОНРТ-ийн “Цагийн хүрд” мэдээллийн хөтөлбөрийг тус тус хамтран бэлтгэж, олон нийтэд цацав.
- Жендэрийн үндэсний хорооны www.gender.gov.mn цахим мэдээллийн сайтыг монгол, англи хэл дээр ажиллуулж байна. Тус сайт дээр Жендэрийн үндэсний хорооны Ажлын албаны цаг үеийн мэдээ, мэдээлэл, хэвлэгдэн гарсан ном товхимол, фото болон видео мэдээллүүд тогтмол нийтлэгдэж байна.
- Мөн нийгмийн сүлжээнд Жендэрийн үндэсний хорооны <https://www.facebook.com/gender.gov.mn> Facebook хуудсыг идэвхитэй ажиллуулж, олон нийтэд жендэрийн эрх тэгш байдлыг хангахтай холбоотой мэдээ, мэдээллийг тогтмол түгээдэг бөгөөд өнөөдрийн байдлаар 5,000 гаруй дагагчтай болоод байна.

1.5. Жендэрийн тэгш байдлын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн төлөв байдлын талаар судалгаа, дүн шинжилгээний ажлыг зохион байгуулах чиглэлээр

- “Монгол улсын жендэрийн нөхцөл байдлын дүн шинжилгээ: 2005 оноос өнөөг хүртэлх ололт ба сургамж” дүн шинжилгээний тайланг боловсруулж, англи, монгол хэлээр хэвлэв. Дүн шинжилгээний тайлан нь “Эдийн засгийн хөгжил ба жендэр”, “Нийгмийн хөгжил ба жендэр”, “Байгаль орчин ба жендэр”, “Жендэрийн тэгш байдлыг хангах үндэсний тогтолцоо” гэсэн 4 сэдвийн хүрээнд боловсруулагдсан. Төрийн болон төрийн бус байгууллага, иргэний нийгмийн байгууллага, олон улсын байгууллагын төлөөлөл зэрэг холбогдох талуудыг оролцуулсан цуврал хэлэлцүүлгүүд болон эцсийн үр дүнг танилцуулах өргөтгөсөн хэлэлцүүлгээс гарсан санал зөвлөмжийг тайланд тусгасан юм.

1.6. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах асуудлаар олон улсын байгууллага, гадаад улстай хийх хамтын ажиллагааг өргөжүүлэх чиглэлээр

- Монгол Улсын Засгийн газар, Швейцарийн хөгжлийн агентлаг, НҮБХАС-ийн санхүүжилттэй хамтран хэрэгжүүлж буй “Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх нь” (2017-2020) төслийн хэрэгжүүлэгч байгууллагаар ажиллаж байна.

Төслийн хүрээнд их, дээд сургуулийн сэтгүүл зүйн ангийн оюутнуудад зориулсан “Жендэрийн мэдрэмжтэй сэтгүүлч” сургалтын гарын авлага боловсруулж хэвлүүлэх, ЖҮХорооны дэргэд Сургалт, судалгааны танхим байгуулах, төрийн албан хаагчдад зориулсан суралт зохион байгуулах, Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр, Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх 16 хоногийн аяны хүрээнд олон нийтийн ойлголт хандлагыг нэмэгдүүлэх кампанит ажлууд өрнүүлэх, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилт дэх жендэрийн үзэл баримтлалын үнэлгээний аргачлалыг нэвтрүүлэх, НҮБ-ын “Эмэгтэйчүүдийн аж

байдлын комисс"-ын чуулганд оролцох зэрэг арга хэмжээг 2019 онд хэрэгжүүлэхээр төлөвлөн хэрэгжүүлж байна.

- Японы улсын ядуурлыг бууруулах сангийн дэмжлэгтэйгээр Азийн хөгжлийн банкт хамтран “Иргэний нийгмийн Байгууллагын оролцоотойгоор жендэрийн тэгш байдлыг хангах нь” техникийн туслалцааны төслийг 2019 оны 8-р сарын 1-ний өдрөөс 2021 оны 8-р сарын 1 хүртэл хэрэгжүүлэхээр Санамж бичиг байгууллаа. Төслийн хэрэгжүүлэгч болон гүйцэтгэгч байгууллагаар Жендэрийн үндэсний хорооны ажлын алба ажиллах юм. Төслийн үр дүнд үндэсний, салбарын болон орон нутгийн түвшинд жендэрийн тэгш байдлыг хангах хөтөлбөрүүдийн хэрэгжилтэд Иргэний Нийгмийн Байгууллагуудын оролцоо нэмэгдсэн байна.

- Монгол Улсын Засгийн газрын санаачилгаар “Эмэгтэйчүүдийг чадавхжуулах, Ази, Номхон далайн бүс нутагт Тогтвортой хөгжлийн 5 дугаар зорилтын хэрэгжилт” сэдвээр тусгай арга хэмжээг НҮБ-ын Ази, Номхон далайн эдийн засаг, нийгмийн комиссын 75 дугаар чуулганы үеэр зохион байгуулав. Тусгай арга хэмжээнд Монгол Улсын Жендэрийн үндэсний хорооны Ажлын албаны дарга Т.Энхбаяр тогтвортой хөгжлийн зорилтуудын хэрэгжилт, жендэрийн тэгш байдлыг хангах чиглэлээрх Засгийн газрын бодлого, үйл ажиллагааг танилцуулж, тулгарч буй бэрхшээл, сайн туршлага, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар дэлгэрэнгүй мэдээлэл хийлээ.

- НҮБ-ын Эмэгтэйчүүдийн асуудлаарх Комиссын 63-р чуулган “Жендэрийн тэгш байдал, охид эмэгтэйчүүдийн чадавхжилтыг дэмжсэн нийгмийн хамгааллын тогтолцоо, нийгмийн үйлчилгээний хүртээмж ба зохистой дэд бүтэц” сэдвээр АНУ-ын Нью-Йорк хотноо зохион байгуулагдсан. Тус чуулганд Жендэрийн үндэсний хорооноос Ерөнхий сайдын жендэрийн зөвлөх Д.Сүхжаргалмаа, ЖҮХ-ны Нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга Т.Энхбаяр, ЖҮХ-ны дэргэдэх Жендэрийн үндэсний шинжээчдийн бүлгийн шинжээч О.Оюунцэцэг нар оролцон төрийн бодлого, үйл ажиллагааг мэдлэг, мэргэжлийн өндөр түвшинд илэрхийлж танилцуулах, улсынхаа байр суурийг хамтын дүгнэлтүүдэд оновчтой тусгах, улсаа өөрийн салбар хуралданаар сурталчлах, цаашдын харилцаа холбоо тогтоох зэрэг шаардлага хэрэгцээг ханган ажиллалаа.

ХОЁР. ХЭРЭГЖИЛТИЙН ШАТАНД ЯВЖ БУЙ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАНИЛЦУУЛГА

2.1. Жендэрийн тэгш байдлыг хангах бодлого, хөтөлбөр, тусгай арга хэмжээг боловсруулах, хэрэгжүүлэх, түүний биелэлтэд хяналт тавих ажлыг зохион байгуулах чиглэлээр

- Жендэрийн үндэсний хорооноос Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимтай хамтран ажиллах харилцан ойлголцлын санамж бичиг байгуулж, хамтран хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулан ажиллаж байна. Энэ хүрээнд Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимтай хамтран шилдэг аж ахуйн нэгж шалгаруулах шалгуурт жендэрийн эрх тэгш байдлын үзүүлэлтийг тусгах ажлыг эхлүүлээд байна.

- Дэлхийн банкны дэмжлэгтэйгээр Сангийн яамтай хамтран хэрэгжүүлж буй Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийн аргачлал боловсруулах, нэвтрүүлэх, турших ажлыг эхлүүлээд байна.

- Эмэгтэйчүүдийг шийдвэр гаргах түвшинд ажиллахад бэлтгэх, чадавхжуулах манлайллыг бий болгох чиглэлээр хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх ажлыг хамтран гүйцэтгэх байгууллагыг сонгон шалгаруулах ажлыг эхлүүлээд байна.

- Улс төрийн болон төрийн захиргааны удирдах албан тушаалд эмэгтэй, эрэгтэй хүнийг санал болгох, нэр дэвшүүлэх, өрсөлдүүлэх шалгуурыг тогтоох, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд заасан квотыг хэрэгжүүлэх нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулах чиглэлээр жендэрийн үндэсний шинжээч Б.Долгортой хамтран ажиллахаар гэрээ байгуулав.

- Нутгийн өөрөө удирдах байгууллагын бодлого, үйл ажиллагаанд жендэрийн үзэл баримтлалыг нэвтрүүлэх чиглэлээр “Нутгийн удирдлагын холбоо” ТББ, жендэрийн үндэсний шинжээч Ш.Солонго нартай хамтран ажиллахаар гэрээ байгуулав.

- Жендэрийн салбар хороодоос орон нутгийн түвшинд сум, баг, хороотой хамтран ажиллах удирдамж боловсруулах чиглэлээр жендэрийн үндэсний шинжээч Т.Амгалантай хамтран ажиллахаар гэрээ байгуулан ажиллаж байна. Орон нутагт зохион байгуулсан бүсийн сургалтын үеэр удирдамжийн төслийг хэлэлцүүлж, гарсан санал зөвлөмжийг тусган ажиллаж байна.

2.2. Жендэрийн тэгш байдлыг хангах бодлогыг хэрэгжүүлэх эдийн засаг, эрх зүйн баталгааг бүрдүүлэх, түүнийг боловсруулах ажлыг арга зүйн удирдлагаар хангах чиглэлээр

- Ерөнхий сайдын 2019 оны 52 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангах хүрээнд МУ-ын урт хугацааны хөгжлийн бодлого, дунд хугацааны төлөвлөгөө боловсруулах дэд ажлын хэсэг байгуулав. Ажлын хэсэг удирдамжийн дагуу өнгөрсөн 25 жилийн хугацаан дахь жендэрийн тэгш байдлыг хангах үндэсний тогтолцоонд дүн шинжилгээ хийх ажлыг гүйцэтгэсэн бөгөөд дараагийн 25 жилд баримтлах стратеги төлөвлөлтийн төслийг бэлтгэн Үндэсний хөгжлийн газарт хүргүүлэхээр ажиллаж байна.

2.3. Жендэрийн тэгш байдлыг хангахад шаардлагатай үндэсний чадавхыг төрийн байгууллагын болон нийгмийн хүрээнд бэхжүүлэх ажлыг зохион байгуулах чиглэлээр

- Жендэр статистик мэдээллийг хөгжүүлэх чиглэлээр Үндэсний статистикийн хорооны WWW.1212.mn мэдээллийн цахим хуудасны “Жендэр” цэсийг Жендэрийн үндэсний хорооны цахим хуудас руу холбов. Жендэрийн статистик бютенийг бэлтгэх хэвлэж тараахаар бэлтгэл ажлыг хангаж байна.

- МУИС-ийн Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхимтэй хамтран сэтгүүл зүйн ангийн оюутнуудад зориулсан “Жендэрийн мэдрэмжтэй сэтгүүлч” сургалтын гарын авлагын төслийг боловсруулж, багш эрдэмтэн судлаач, жендэрийн үндэсний шинжээчдийн дунд хэлэлцүүлээд байна. Хэлэлцүүлгээс гарсан санал зөвлөмжийг тусган эцсийн хэлэлцүүлийг зохион байгуулсны дараа гарын авлагыг хэвлүүлж, сэтгүүл зүйн чиглэлээр сургалт явуулдаг их, дээд сургуулийн багш нарт танилцуулан түгээх ажлыг төлөвлөж байна.

2.4. Жендэрийн тэгш байдлын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн төлөв байдлын талаар судалгаа, дүн шинжилгээний ажлыг зохион байгуулах чиглэлээр

- Монгол Улсын Ерөнхий сайдын 2019 оны 60 дугаар захирамжаар “Эрэгтэйчүүдийн эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлт, нийгэм, соёл, эдийн засгийн идэвх оролцоо, тэднийг үнэлэх үнэлэмж, хандлага, гэр бүлийн хүрээнд тулгамдаж байгаа асуудалд суурь судалгаа хийх” ажлын хэсэг байгуулав. Ажлын

хэсгийн гишүүд бодлогын түвшинд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж, судалгаанд шаардлагатай мэдээллээр хангаж ажиллана. Судалгааг Дэлхийн банкны дэмжлэгээр Судалгаа шинжилгээний Эс Ай Си Эй (SICA) байгууллага хийж гүйцэтгэх юм. Түүнчлэн салбар яамд болон холбогдох төрийн бус байгууллагуудын төлөөллийг багтаасан дэд ажлын хэсгийг ҮСХ-ны Хүн ам, нийгмийн статистикийн газрын даргаар ахлуулан байгуулж ажлыг эхлүүллээ.

- “Нийгмийн даатгалын сангаас олгох өндөр насны тэтгэвэр авагчдын дунд судалгаа хийх” ажлын хүрээнд тэтгэвэр авагчдын тэтгэврийн хэмжээ, нийгмийн даатгалын шимтгэл төлсөн хугацаа, тэтгэвэр авах дундаж хугацаа, тогтолцоо хоорондын шилжилтээс хамаарсан тэтгэврийн ялгаа, тэтгэвэр тогтоолгох эрх үүссэн нөхцөл зэргийг харьцуулан судлах ажлыг ХНХЯ-ны Нийгмийн хамгааллын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газартай хамтран хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

2.5. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах асуудлаар олон улсын байгууллага, гадаад улстай хийх хамтын ажиллагааг өргөжүүлэх чиглэлээр

- Азийн Хөгжлийн Банкны дэмжлэгтэй “Ази, Номхон далайн орнууд дахь уур амьсгалын өөрчлөлт, гамшгийн эрсдэлийг даван туулах эмэгтэйчүүдийн чадавхийг бэхжүүлэх” техник туслалцааны төслийг 2018-2020 онд хэрэгжүүлэхээр ажиллаж байна. Төслийн гүйцэтгэгч байгууллагаар Жендэрийн Үндэсний Хорооны ажлын алба, Төслийн хэрэгжүүлэгч байгууллагаар Азийн Сан ажиллаж байгаа бөгөөд эмэгтэйчүүдэд зориулсан ногоон ажлын байрыг бий болгох туршилтын төслийг хэрэгжүүлэхэд Хүнс, Хөдөө Аж Ахуй, Хөнгөн Үйлдвэрийн Яам хамтран ажиллаж байна.

ГУРАВ. ТӨСВИЙН ЗАРЦУУЛАЛТ

Жендэрийн тэгш байдлыг хангах төрийн чиг үүргийг хэрэгжүүлэх чиглэлээр 2019 онд Жендэрийн үндэсний хорооны зардалд улсын төсвөөс 706,809,300 сая төгрөг, олон улсын байгууллагын тусламжаар хэрэгжүүлж буй төслөөс 217,050,500 сая төгрөгийн санхүүжилт батлуулсан.

2019 оны батлагдсан төсвийн зарцуулалтыг хүснэгтээр харуулвал:

Д/д	Эх үүсвэр	2019 оны батлагдсан төсөв	Эхний хагас жилийн зарцуулалт	Зарцуулалтын хувь
1.	Улсын төсөв: Үүнээс	706,809,300	242,982,664	34,4%
	Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний зардал	300,000,0000	124,417,360	41,5%
	Үйл ажиллагааны зардал	406,809,300	118,565,304	29,1%
2.	Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх нь төсөл	217,050,500	105,287,070	48,5%
	Нийт дүн:	923,859,800	348,269,734	37,6%

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ

Чиглэл тус бүрээр хүрсэн гол үр дүн:

✓ Жендэрийн үндэсний хорооны Ажлын албыг 2019 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн Монгол Улсын Ерөнхий сайдын дэргэд ажиллуулахаар шийдвэрлэж, Ажлын албаны орон тоог 8 болгон нэмэгдүүлж, 2019 оны улсын төсөвт цалингийн сан болон үйл ажиллагааны зардлыг Ерөнхий сайдын төсвийн багцад тусган, 706.8 сая төгрөгийг баталсан.

✓ 2014-2018 онд 7 салбарт жендэрийн талаар баримтлах бодлогыг батлуулсан бол 2019 онд 3 салбарын хүрээнд баримтлах жендэрийн дэд хөтөлбөр боловсруулагдан батлагдахаар байна. Мөн хугацаанд 14 аймгийн дэд хөтөлбөрийг батлуулсан бол 2019 онд 2 аймгийн дэд хөтөлбөр батлагдаж, 2 аймаг дэд хөтөлбөрийн төслийг боловсруулж батлуулахад бэлэн болсон, 3 аймаг дэд хөтөлбөр боловсруулах ажлыг эхлүүлээд байна. Нийслэл, нийслэлийн 9 дүүрэгт тухайн шатны Засаг даргын захирамжаар жендэрийн дэд хөтөлбөр боловсруулах 10 ажлын хэсэг байгуулагдаж жендэрийн мэдрэмжтэй бодлого төлөвлөлтийг нэвтрүүлэх ажил амжилттай хэрэгжиж байна.

✓ Жендэрийн үндэсний хорооны дэргэд иж бүрэн тоногдсон Сургалт, судалгааны танхим байгуулагдаж, 31 сургагч багшийг сургаж бэлтгэв. Төрийн албан хаагчийн мэргэшүүлэх багц сургалтын агуулгад жендэрийн агуулгыг нэвтрүүлэх ажлыг Удирдлагын академитай хамтран хэрэгжүүлэх ажлыг эхлүүллээ.

✓ Жендэрийн талаарх олон нийтийн хэвшмэл ойлголт, хандлагыг өөрчлөх хүрээнд Жендэрийн үндэсний хороо, Монголын Үндэсний Олон Нийтийн Радио Телевизтэй хамтран ажиллах Харилцан ойлголцлын санамж бичиг байгуулж, телевизийн нэвтрүүлгийн төлөвлөгөөг батлуулан хэрэгжүүлж эхлээд байна.

✓ “Монгол улсын жендэрийн нөхцөл байдлын дүн шинжилгээ: 2005 оноос өнөөг хүртэлх ололт ба сургамж” дүн шинжилгээний тайланг боловсруулж, англи, монгол хэлээр хэвлэж, холбогдох талуудад хүргүүлэв.

✓ “Иргэний нийгмийн Байгууллагын оролцоотойгоор жендэрийн тэгш байдлыг хангах нь” техникийн туслалцааны төслийг 2019 оны 8-р сарын 1-ний өдрөөс 2021 оны 8-р сарын 1 хүртэл хэрэгжүүлэхээр Санамж бичиг байгууллаа.

ЖЕНДЭРИЙН ҮНДЭСНИЙ ХОРООНЫ АЖЛЫН АЛБА